

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЗАХИАЛАГЧИЙН АЛБАНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.06.02

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2022 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн “Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 04/22 тоот удирдамжийн хүрээнд Хөрөнгө оруулалт, захиалагчийн хангалтын албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, ахлах мэргэжилтэн М.Мөнгөншагай, аудитор А.Мөнх-Эрдэнэ, О.Сэндэр, Ц.Оюут, мэргэжилтэн Б.Анусэцэн нарын бүрэлдэхүүнтэй баг 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналт, төсөл арга хэмжээ, худалдан авах ажиллагааг зохион байгуулалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт зэргийг нягталж шалгахад гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Үнэлгээний хорооны ажлыг шалгахад нийт 103 ажилд оролцсон үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нар “Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг”-т Сангийн сайдын 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 1.5-д дахь заалтыг тусгаагүй.

ИНҮТ-ийн даргын баталсан “Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-ний худалдан авах ажиллагаанд мөрдөх хугацааг ИНҮТ-ийн даргын тушаалаар батлагдсан 2021 оны үнэлгээний хороо байгуулагдсан тушаалуудын огноотой харьцуулахад хугацаанаас 30-аас дээш хоногоор хэтэрч ТББ-ийг боловсруулж, тендер зарласан нийт 47 ажил байна.

“Иргэний нисэхийн үндэсний төвийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах журам”-ын 4.3.3-т заасан “...нээсэн өдрөөс хойш ажлын 10 хоногт багтааж” гэснийг Сангийн сайдын 2014 оны “Журам шинэчлэн батлах тухай” 212 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.3-т “Тендер шалгаруулалтыг нээсэн өдөр үнэлгээний хороо эхний хуралдааныг хийх” гэсэнд нийцүүлэн өөрчлөх,

ИНҮТ-ийн даргын 2021 онд байгуулсан худалдан авах гэрээний огноог тус гэрээг байгуулахад “Гэрээний төсөлд санал авах хуудас”-ны баталгаажсан огноотой харьцуулахад нийт 84 гэрээ байгуулсны 47 нь хугацааны хувьд зөрүүтэй буюу гэрээ байгуулагдсанаас хойш санал авсан байна.

Дотоод аудит, хяналт шалгалт хийх хугацаанд нийт 103 тендер шалгаруулалтын ажлын хавтаст хэргийг шалгахад 16-н ажлын үнэлгээний хорооны тэмдэглэлд бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.8-д “Үнэлгээний дүгнэлтэд хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглэж гарын үсгээ зурна.” заасантай нийцэхгүй байна.



Худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг шалгахад хөндлөнгийн 2 гишүүн ажиллуулсан боловч 1 гишүүн нь ИНЕГ-ын харьяанд ажиллаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, ... оролцуулна”, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан журмын 2.2-т “Хуулийн 47.6-д заасны дагуу Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх бөгөөд хуулийн 47.4-т заасан төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд заавал оруулна” гэж заасан шаардлагыг бүрэн хангахгүй гэж үзэж болохоор байна.

ХОЗА-ны 2021 оны худалдан авах ажиллагааны архив, хавтаст хэргийг шалгахад 3 ажилд албан хэрэг хөтлөлтийн стандарт хангаагүй зөрчил илэрсэн.

ХОЗА-ны 2021 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны архивын нэгжийг шалгахад Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг бүрэн бус бөглөсөн, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг бүрэн бус бөглөсөн зөрчил илэрсэн.

Барааг хүлээн авах ажиллагаа дуусаагүй байхад гэрээг дүгнэсэн, гэрээний хугацаандаа нийлүүлээгүй байхад гэрээг сунгаагүй, алданги тооцоогүй нь ИНЕГ-ын даргын 2021 оны А/14 дүгээр тушаалаар баталсан Иргэний нисэхийн ерөнхий газрын гэрээ байгуулах журмын 7.2 дахь заалтыг зөрчсөн.

ИНҮТ-тэй 2021 онд гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллаудын хүлээн авах комисс томилж бараа, ажил, үйлчилгээг хүлээлгэн өгөх хүсэлт өгсөн огноог ИНҮТ-ийн даргын тушаалаар байгуулагдсан хүлээн авах комисс томилсон огноотой харьцуулахад 22 ажлыг 10-аас 44 хоногт хүлээн авах комисс томилсон. Мөн бараа, ажил, үйлчилгээ хүлээн авах комиссын актаас гэрээ дүгнэсэн хугацааг харьцуулахад 10-аас 75 хоногт гэрээг дүгнэсэн 16 ажил тус тус байгаа нь тухайн ажиллагаа удаашралтай байгааг харуулж байна.

Ажил хүлээн авах комисс томилогдохоос өмнө бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан, тендерийн баримтыг хавтаст материалд хавсаргаагүй зөрчил илэрснээс шалгалтын явцад зөрчлийг арилгуулсан.

ИНҮТ-ийн ХОЗА-ны 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй, дутуу мэдээлдэг зэрэг зөрчлүүд илэрсэн.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Хөрөнгө оруулалт, захиалагчийн албанд 12 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА